

## АГУУЛГА

Нэг. Ерөнхий тойм

Байгууллагын үндсэн үйл ажиллагаа

- 1.1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хийсэн ажил
- 1.2. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн
- 1.3. Хууль, дүрэм, журам, төлөвлөгөөний төсөлд санал өгөх талаар
- 1.4. Удирдлага, зохион байгуулалтын хийж хүрээнд хийсэн ажил
- 1.5. Бусад байгууллагатай хамтран ажиллах хүрээнд
- 1.6. Хүний нөөцийн ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 1.7. Сургалтын ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 1.8. Санхүү төлөвлөлт, аж ахуйн ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 1.9. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдол, шийдвэрлэлтийн ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 1.10. Мэдээллийн технологийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил
- 1.11. Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 1.12. Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах сурталчилах ажлын хүрээнд

Хоёр. Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаа

- 2.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.2. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.4. Бичиг баримтжуулах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.5. Улсын бүртгэлийн архивын ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

Гурав. Нөхөн сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

Дөрөв. Ковид-19 цар тахлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Тав. Бэлэн байдлын үзлэг зохион байгуулах чиглэлээр

Зургаа. Сайн үйлсийн аяны хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

Долоо. Бусад ажлын чиглэлээр

Найм: Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

# НИЙСЛЭЛ ДЭХ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## НЭГ. ЕРӨНХИЙ ТОЙМ

Нийслэл дэх улсын бүртгэлийн газар нь нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төрөөс явуулж буй бүртгэлийн талаарх бодлого чиглэл, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2022 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө, дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж, хэлтэс, нэгжүүдийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хуульд заасан улсын бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээг үзүүлэх гэсэн 2 үндсэн чиг үүргийн хүрээнд Газрын дарга, Захиргаа удирдлагын хэлтэс /11/, Харилцагчийн үйлчилгээний хэлтэс /4/, Архивын хэлтэс /9/, Дүүргүүд дэх улсын бүртгэлийн хэлтэс /385/ гэсэн нэгжүүдтэйгээр нийт 410 ажилтан, албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллалаа.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын 1.539.252 /нэг сая таван зуун гучин есөн мянга хоёр зуун тавин хоёр/ гаруй оршин суугчдад төрөөс явуулж буй улсын бүртгэлийн талаарх бодлого шийдвэрийг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж, өөрийн харьяа 187 нэгжээс Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжид заасны дагуу бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна.

### **1.1.Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:**

Тус газар нь “Алсын хараа-2050” зорилт 5.3, 7.4, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, 7.4, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 5.2.2 хэсгийн хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байна.

Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар эцэслэн баталж, 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт “Иргэний үнэмлэхийг тоон гарын үсгийн хэрэгслээр ашиглаж болох бөгөөд энэ хуулийн 8.3-т заасан мэдээллийг түүний санах ойд байршуулна” гэж заасан.

Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн тоон гарын үсэг олгох ажлыг нийслэлийн хэмжээнд дүүргүүд дэх улсын бүртгэлийн хэлтэс, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдээр олгохоос гадна Хууль Зүй, Дотоод Хэргийн сайдын 2022 оны 5 дугаар сарын 22-ны 1/2677 тоот чиглэлийн 3-т дурьдсан Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэн хууль сахиулах байгууллагын албан хаагчид, төрийн байгууллагын албан хаагчид болон дүүргүүдийн нутаг дэвсгэрт байрлах аж ахуй нэгж байгууллагуудад тоон гарын үсэг олгох үйл ажиллагааг хуваарийн дагуу зохион байгуулан ажиллаж байна. Тайлангийн хугацаанд нийт **34240** иргэнд тоон гарын үсэг олгосон байна.







## **1.2 Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн:**

Энэ оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын 2 тогтоолын 6 заалт, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 8 заалт, нийт 5 шийдвэрийн 14 заалтыг хяналтанд авч хэрэгжүүлэн ажиллалаа. Эдгээрээс тайлант хугацааны зорилтод бүрэн хэрэгжсэн 14 байгаа бөгөөд хэрэгжилт 100 хувьтай байна.

Тайлангийн хугацаанд **Улсын бүртгэлийн ерөнхий газраас:** Хүний нөөцтэй холбоотой 91 тушаал, үүрэг, чиглэл 13, **Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас:** Нийслэлийн Засаг даргын захирамж-2, нийслэлийн Засаг даргын хуралдааны тэмдэглэл-2, Чиглэл 3, Зөвлөмж 1, Нийслэлийн онцгой комиссоос: үүрэг чиглэл 2, хурлын тэмдэглэл 2, тушаал 1, зөвлөмж 2 тус тус ирснийг хяналтанд авч, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар төрийн захиргааны байгууллага, агентлагийн дарга нарт үүрэг болгосон заалт бүрийг хяналтад авч, хяналтын хуудас хөтлөн ажиллаж байна.

## **1.3 Хууль, дүрэм, журам, төлөвлөгөөний төсөлд санал өгөх талаар**

Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон төрийн бусад байгууллагаас санал авахаар ирүүлсэн дараах хууль, дүрэм, журмын төсөлд санал өгч ажиллав. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль
- Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
- Орон сууцны ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга
- Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

- Төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний баримт бичигт
- Монгол Улсын иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журам
- Нийтийн мэдээллийн дэд бүтэц төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл хөтөлбөр арга хэмжээний нэгдсэн бүртгэл хөтлөх журам
- Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж байгаатай холбогдуулан үйл ажиллагаандаа мөрдөгдөж буй дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал
- Төр өөрт байгаа мэдээллийг иргэдээс нэхэхгүй байх тал дээр холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах тухай санал
- Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний төсөлд санал -1 удаа
- Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний санал-1 удаа
- ХЗДХЯ-ны сайд НЗД-тай байгуулах хамтран ажиллах гэрээний санал-1 удаа
- “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”, “Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэхэд зардал тооцох аргачлал” болон батлах гэрээний загварын төсөлд санал
- "Хотын стандарт"-ын төсөл
- Хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулах зэрэг 15 хууль, дүрэм, журмын төслийг тус тус албан хаагчдад танилцуулж, саналыг холбогдох газруудад хүргүүлсэн байна.

#### **1.4 Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:**

**Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллав.**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралд 2, шуурхай хуралдаанд 7, холбогдох ажлын хэсгүүдийн хурал, мөн Нийслэлийн Засаг даргын шуурхай хуралдаанд 13 удаа, Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тухай бүр тус тус оролцож, өгөгдсөн үүрэг даалгаврын хүрээнд газрын удирдах албан хаагчдын шуурхай хуралдааныг 8 удаа зохион байгуулж, хурлаас нийт 82 үүрэг даалгавар өгч, биелэлтийг гарган ажиллаж байна.

Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын даргын 46 тушаал, 1 гэрээний төслийг боловсруулж, батлав.

Мөн дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүдэд 3 удаагийн чиглэл, зөвлөмж үүрэг боловсруулан хүргүүлсэн.

**Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон бусад дээд газарт тайлан, мэдээ, судалгааг хүргүүлэх чиглэлээр:**

Тус газар нь 2022 оны эхний хагас жилийн нийт 55 төрлийн тайлан, мэдээг давхардсан тоогоор 180 удаа холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний төсөлд санал -1 удаа
2. Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний санал-1 удаа

3. ХЗДХЯ-ны сайд НЗД-тай байгуулах хамтран ажиллах гэрээний санал-1 удаа
4. Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт-1 удаа
5. "Хотын стандарт"-ын төсөлд-1 удаа
6. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт-1 удаа
7. Нийслэлийн Засаг даргаас Хууль Зүй, Дотоод Хэргийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлт-1 удаа
8. Улсын бүртгэлийн ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт-2 удаа
9. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн тайлан-2 удаа
10. Газрын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирлаар, хагас жилээр -3 удаа
11. Газрын хагас жилийн үйл ажиллагааны тайланг -2 удаа
12. "Нэг хот-нэг стандарт" төлөвлөгөөний хэрэгжилт 2 удаа
13. Хууль зүй дотоод хэргийн сайдаас өгсөн шуурхай хурлын биелэлт -2 удаа
14. Улсын бүртгэлийн ерөнхий газрын шуурхайн биелэлтийг-6 удаа
15. Нийслэлийн Засаг даргын шуурхай хурлын биелэлт -13 удаа
16. Иргэний улсын бүртгэлийн сарын тоон мэдээ-5 удаа
17. Лавлагааны тоон мэдээ -5 удаа
18. Төсвийн гүйцэтгэл-5 удаа
19. Нийгмийн даатгалын тайлан-5 удаа
20. Газрын хүн амын орлогын албан татварын тайлан -1 удаа
21. Газрын орлогын тайлан-5 удаа
22. Үнэт цаасны бар кодын тайлан-5 удаа
23. Сарын үйл ажиллагааны тайлан -5 удаа
24. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн тайлан-улирал, хагас жилээр-2 удаа
25. Нийслэлийн Засаг даргын албан даалгаварын хэрэгжилтийн тайлан-улирал, хагас жилээр-2 удаа
26. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт -1 удаа
27. Жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар зохион байгуулах ажлын төлөвлөгөөний хэрэгжилт-1
28. Сургалт, сурталчилгааны төлөвлөгөөний хэрэгжилт-1 удаа
29. 7 хоногийн ажлын мэдээ -20 удаа
30. Бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажилласан тухай өдөр тутмын мэдээлэл- 34 удаа
31. Жендерийн төлөвлөгөөний санал Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 1 удаа
32. Орон сууцны ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал -1 удаа
33. Түүхий нүүрсний хэрэглээ, сайжруулсан түлшний нөөцлөлт, борлуулалт, тээвэрлэлтэд хяналт тавьж ажиллах нутгийн захиргааны байгууллагуудын мэдээ-12 удаа

- 34.Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан-улирлаар, хагас жилээр-4 удаа
- 35.Нийслэлийн төрийн албаны зөвлөлд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн тоон мэдээ-1 удаа
- 36.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд шилжилт хөдөлгөөний мэдээ -1 удаа
- 37.Нууцын тайлан-1 удаа
- 38.“Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөө”-ний биелэлтийг 1 удаа
- 39.Албан хаагчдын зэрэг дэвийн санал -1 удаа
- 40.Албан хаагчдын цалин нэмэгдүүлэх санал-1 удаа
- 41.Бүтэц, орон тооны санал -1 удаа
- 42.Бэлэн байдлын үзлэгтэй холбоотой чиглэл -1 удаа
- 43.Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдын судалгаа-1 удаа
- 44.Албан хаагчдын ажил, гэрийг ойртуулах судалгаа-1 удаа
- 45.Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх, төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний бодлогын баримт бичиг”-ийн төслийн санал-1 удаа
- 46.Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж байгаатай холбогдуулан үйл ажиллагаандаа мөрдөгдөж буй дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал-1 удаа
- 47.Төр өөрт байгаа мэдээллийг иргэдээс нэхэхгүй байх тал дээр холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах тухай санал -1 удаа
- 48.Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх системийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд хийх ажлын санал-1 удаа
- 49.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд оруулах санал-1 удаа
- 50.“Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”, “Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэхэд зардал тооцох аргачлал” болон батлах гэрээний загварын төслийн санал-1 удаа
- 51.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн боловсруулсан журмын төслийн санал-1
- 52.Хөдөлмөрийн дотоод журмын санал -1 удаа
- 53.2021 оны эрсдэлийн тайлан -1 удаа
- 54.Хил нэвтрэх үнэмлэхтэй албан хаагчдын судалгаа -1 удаа
- 55.2022 оны эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны санал -1 удаа удаа тус тус хүргүүлэв.

### **1.5 Бусад байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр:**

Тус газар нь 2022 оны эхний хагас жилд өөрийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, дүүргүүдийн Засаг даргын

Тамгын газар, Нийгмийн халамжийн газар, Нийгмийн даатгалын газар, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, “Гэр бүл хүүхэд залуучуудын газар”, “Хотын засаглалыг сайжруулах” төсөл, бүх шатны ерөнхий боловсролын сургуулиуд, хууль хяналтын болон холбогдох төрийн бүх шатны байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Мөн өөрийн ажил үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор “Гэрэгэ системс” ХХК, “Улаанбаатар Буян” ХХК “Азийн хөгжлийн сан”, “Монгол Шуудан” ХХК, “Дэлхийн Зөн” олон улсын байгууллага, “Зөв амьдрах ухаан” төрийн бус байгууллага, “Голомт банк”, “Богд банк”, “Хаан банк” зэрэг байгууллагуудтай хамтран ажилласан.

“Хотын засаглалыг сайжруулах” төслийн хүрээнд харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан баррель үсэг бүхий гарын авлагын эхийг бэлтгэн 200 ширхэгийг хэвлүүлэн хэлтэс, нэгжүүдэд хүргүүлсэн.

Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газартай дараах байдлаар хамтран ажилласан байна. Үүнд:

**Багануур дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь:**

1. Тус хэлтэст шаардлагатай байгаа 72 050 000 төгрөгийн /цахим үйлчилгээний киоск машин 1, хороодод үйлчилгээний хураамж тушаах Гэрэгэ киоск машин 4, үйлчилгээний дараалал зохицуулах машин 1, явуулын үйлчилгээ үзүүлэх иж бүрдэл бүхий төхөөрөмж 1 техник, тоног төхөөрөмжийн судалгааг Дүүргийн Засаг даргад хүргүүлсэн.

**Багахангай дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь:**

1. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 өрөөнд буюу нийт 140 м2 талбайд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байна. Дүүргийн удирдлагуудад архивын өрөө, бусад өрөө тасалгаа шаардлагатай байгаа талаар албан бичиг хүргүүлсэн.

**Баянгол дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь:**

1. Дүүргийн Засаг даргын дэмжлэгээр 3,6,18 дугаар хороонд 3 ширхэг пос машиныг шийдвэрлүүлсэн.
2. Лавлагаа мэдээллийн машиныг дүүргийн Засаг даргын дэмжлэгээр захиалсан бөгөөд нийлүүлэлт хийгдэхэд бэлэн болсон.

**Баянзүрх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь:**

1. Нийслэлийн хамгийн ачаалалтай Баянзүрх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс үйлчилгээний танхимын зай талбай бага, албан хаагчдын ажлын ачааллыг бууруулах, төрийн үйлчилгээг иргэдэд ая тухтай үзүүлэх зорилгоор Баянзүрх дүүргийн Тамгын газрын “Төр Захиргааны II дугаар байр”-нд улсын бүртгэлийн үйлчилгээг явуулахад техник тоног төхөөрөмж болон хүний нөөцийн асуудлыг дотооддоо шийдэж 2022 оны 2 дугаар сарын 7-ны өдрөөс эхлэн дүүргийн зүүн бүсийн иргэдэд бүртгэлийн үйл ажиллагаа явуулж байна.
2. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын байранд үйл ажиллагаа явуулж буй Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааг хэвийн явуулах, албан



хаагчдын ажиллах орчныг сайжруулах үүднээс 4 өрөөнд засвар үйлчилгээг хийсэн.

3. Мөн Жанжин клуб, Дарь-Эх бүсэд нэг цэгийн үйлчилгээг нэмж ажиллуулахаар бэлтгэл ажлыг ханган ажилласан.

#### **Налайх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь:**

1. “Гэрэгэ” ХХК-тай хамтран киоск машиныг алслагдсан 5,6 дугаар хороонд нэмж байршуулсан.

#### **Сонгинохайрхан дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь:**

1. Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэж, албан хаагчдын ажлын байрны нөхцөлийг сайжруулж дүүргийн Нутгийн захиргааны нэгдсэн байрны 1,2-р давхарт үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн дүүргийн Засаг даргын Тамгын газар болон хорооны Засаг дарга нартай хамтарч 23 хорооны улсын бүртгэгчийн ажиллах орчин нөхцлийг сайжруулж бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх өрөө тасалгаатай болгосон.
2. Дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газартай хамтран шинээр 14, 32-р хороонд пос машин байршуулсан.

#### **Сүхбаатар дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь:**

1. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2022 оны А/167 дугаар захирамжаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх ажлыг зохион байгуулж уг ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх өрөөг бэлтгэн тохижуулж хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн эхчүүд, өндөр настан иргэдэд бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна.
2. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгөөр дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст 2022 онд 15 пос машин шийдвэрлүүлэн үйлчилгээний хураамжийг иргэн, хуулийн этгээдэд чирэгдэлгүй түргэн шуурхай үзүүлж байна.

#### **Хан-Уул дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь:**

1. Дүүргийн Засаг даргын дэмжлэгээр 13, 14, 16, 21 дүгээр хороодод “Гэрэгэ киоск” төлбөрийн машиныг 2022 оны 4 дүгээр сард суурьлуулсан.
2. Дүүргийн нэг цонхны үйлчилгээний танхимд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 2 цонх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 1 цонх, иргэний улсын бүртгэлийн 2 цонхоор иргэдэд бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байна. Мөн дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэмжлэгээр тус хэлтсийн албан хаагчдын байрлаж буй 2 давхарын өрөө тасалгаанд 4 дүгээр сарын 1-нээс 8-ны өдрүүдэд засварын ажил хийгдэж дууссан. Мөн өрөө тасалгааны багтаамжийг 6 мк2-аар нэмэгдүүллээ.

#### **Чингэлтэй дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь:**

1. Дүүргийн санхүүжилтээр 33,000,000 сая төгрөгөөр нийт 19 хороог пос машинтай болгосон ба шинээр байгуулагдаж буй 20, 21, 22, 23, 24 дүгээр хороодод мөн нөөцтэйгөөр шийдвэрлэн ажилласан

2. Ажиллагсдын ажиллах орчныг сайжруулах зорилгоор дүүргийн “Нэг цонх”-ны үйлчилгээний танхимд засварын ажил 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхэлсэн бөгөөд 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдөр хүлээн авах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

### 1.6. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон албан хаагчийг томилох, тушаал дэвшүүлэх, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэж ажиллалаа.

2022 оны эхний хагас жилийн байдлаар шинэчлэн гаргасан 357 албан хаагчдын ХАСХОМ-ын мэдүүлгийг хүлээн авч, цахим системд баталгаажуулан, Улсын бүртгэлийн ерөнхий газарт тайлан мэдээ хүргүүлсэн. Мэдүүлэг гаргахаас татгалзсан болон хугацаа хоцроож мэдүүлсэн албан хаагч байхгүй. Шинээр томилогдсон 39, их хэмжээний өөрчлөлт мэдүүлсэн 6 албан хаагчийн 2021 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авч, цахим системд баталгаажуулсан байна.

Хүний нөөцийн чиглэлээр 23 нэр төрлийн судалгааг гарган удирдлагад танилцуулж, холбогдох газарт хүргүүлсэн байна. Судалгаанд давхардсан тоогоор 2800 орчим хүн хамрагдсан байна. Төрийн үйлчилгээний 3 албан хаагчийн хувийн хэрэгт баяжилт хийсэн.

Тус газрын албан хаагчдын 2021 оны гүйцэтгэлийн тайланг үнэлсэн үнэлгээний хуудсыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын хүний нөөцийн програмд оруулж цахимжуулсан. Нийт 362 албан хаагчийн 1810 хуудас бүхий материалыг цахимжуулсан байна.

Албан хаагчдын орж гарсан хөдөлгөөнийг тухай бүр бүртгэж, систем ашиглан цалин бодогдож байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхээр газрын даргаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу 9 дүүргийн албан хаагчдын ажлын байрын зураг авалтыг 2022.06.07-06.09-ний хооронд хийж гүйцэтгэн тайланг танилцуулахад бэлэн болсон.

Төрийн албаны зөвлөлийн аудитын багийн шаардсан 12 төрлийн судалгаа, тоон мэдээг Тамгын газрын даргын үүрэг болгосны дагуу хугацаанд нь гаргаж өгч мэдээ мэдээллээр хангасан.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд шинээр томилогдсон 61 албан хаагчаас “Нууцын баталгаа”-г гаргуулан авсан. Орон нутгийн сонгуулиар ажиллах Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн саналын дагуу 5 итгэмжлэгдсэн ажилтан томилох тухай тушаалыг гаргаж, нууцын баталгаа гаргуулсан. Нийт 66 албан хаагчаас “Нууцын баталгаа” гаргуулсан.

Монгол Улсад Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан тус газрын албан хаагчдын ажлын цаг ашиглалт, ирцийн байдалд хяналт тавих, албан хаагч ажил тасалсан, хожимдсон тохиолдолд түүнд ажилласан хугацааны цалинг тооцож олгох зорилгоор цаг бүртгэлийн цахим програмыг нэвтрүүлэн турших ажлыг


эхлүүлэн газрын даргын А/12 дугаар тушаалаар албажуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

### 1.7 СУРГАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД

Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан “Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын сургалтын төлөвлөгөө”-г баталж, **147** удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор **5791** ажилтан, албан хаагч хамруулсан. Үүнд:

- ❖ Улсын бүртгэлийн ерөнхий газраас-44 удаагийн сургалтаар-2198
- ❖ Нийслэл дэх Улсын бүртгэлийн газраас-27 удаагийн сургалтаар-768
- ❖ Дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүд-31 удаагийн сургалтаар-690
- ❖ Бусад төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан-45 удаагийн сургалтанд -2135

**Иргэдэд зориулсан эрх зүйн сургалтын хүрээнд:** Иргэд, харилцагчдад зориулсан **44** удаагийн сургалтаар **10842** харилцагчид хамрагдсан байна.



2021 оны мөн үетэй харьцуулбал зохион байгуулсан сургалтын тоо 2 дахин өсч, сургалт явуулах арга хэлбэрийг улам боловсронгуй болгож нийт сургалтын ихэнх хувийг цахимаар зохион байгуулсан байна.

### 1.8 САНХҮҮ, АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:

Газрын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Олон улсын стандартад нийцүүлэн батлагдсан маягт зааврын дагуу хөтлөх, газрын болон дүүргүүд дэх улсын бүртгэлийн хэлтсийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх, байгууллагын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх чиг үүргийн хүрээнд ажиллаж байна.

#### Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

- ❖ Байгууллагын нэгдүгээр улирлын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.
- ❖ Нийгмийн даатгал, хүн амын орлогын албан татвар, улсын тэмдэгтийн хураамжийн тайланг тус тус хугацаанд нь хүргүүлсэн.
- ❖ Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган мэдээллийг цаг хугацаанд нь оруулсан. 2 мэдээлэлд засвар оруулсан.
- ❖ УБЕГ-ын тайлан, мэдээ гаргах журмын дагуу сар бүр тайланг дараа сарын 2-ны дотор хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

#### Байгууллагын хэвийн үйл ажиллагааг тасалдалгүй ханган ажиллах хүрээнд:

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж төсвийг үр бүтээлтэй зарцуулах, хуваарилах, төлөвлөх ажлыг хийж гүйцэтгэсний үр дүнд төсөв /2807.1 сая/ хэтрээгүй.

Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах санал 2 удаа хүргүүлж өр авлагагүй ажилласан.

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг тогтмол төвлөрүүлсэн.

**2022 оны эхний 5 сарын байдлаар дараах орлогыг төвлөрүүлэн ажилласан байна.**

Д/Д	Хугацаа	Орлого, зардлын зүйл анги	Үйлчилгээний төрөл	Мөнгөн дүн /өссөн дүнгээр/
1	2022 оны 5 дугаар сарын байдлаар	Улсын төсөвт	Үйлчилгээний орлого	4,6 тэрбум
2		Орон нутгийн төсөв	Торгууль шийтгэврийн орлого	419,1 сая
			Тэмдэгтийн хураамж	846,6 сая
			Үл хөдлөх хөрөнгийн татвар	23,4 тэр бум

**Үндсэн хөрөнгө, бараа материалын орлогыг үнэн зөв хүлээн авч зарцуулалтанд хяналт тавьж ажиллалаа.**

#### Зарцуулалт, хуваарилсан /үндсэн хөрөнгө/

Акталж ашиглалтаас хассан	Дахин үнэлж, шилжүүлсэн
29 нэр төрлийн 49,6 сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийг актлах шийдвэр гаргуулж Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.	1224 нэр төрлийн 517,6 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг дахин үнэлж, хуваарилсан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар олгосон 29.431.500 төгрөгийн үнэтэй 14 ширхэг үндсэн хөрөнгийг Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын даргын тушаалаар дансанд бүртгэн авч хэлтэс, нэгжүүдэд хувиарлан тараасан.

Мөн Нийслэлийн Өмчийн харилцааны газраар 3 нэр төрлийн 16 ширхэг 44.594.000 төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалаас үндсэн хөрөнгө рүү шилжүүлж бүртгэж авч дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүдэд хувиарласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн 2 авто тээврийн хэрэгслийг Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын нэр дээр шилжүүлэх ажлыг Авто тээврийн үндэсний төвөөр гаргуулсан. 5 авто тээврийн хэрэгслийг Монгол даатгалд даатгуулсан.

#### Орлого/ бараа материал/

#### Улсын бүртгэлийн ерөнхий газраас

37 нэр төрлийн 225306 ширхэг 67,4 сая төгрөг

Ажилчин албан хаагчдын цалин хөлс, урамшуулалыг цаг хугацаанд нь бодож олгож цагийн бүртгэл бусад тооцоололд хяналт тавьж ажиллаа.

Үзүүлэлт /сая.төг/	Батлагдсан төсөв	Нийт төсөв	Олгосон
Цалин хөлс	2218,1	2218,1	2218,1
НДШ	536,8	536,8	536,8
Нийт	2754.9	2754.9	2754.9

Улсын бүртгэлийн ерөнхий газраас давхардсан тоогоор 225314 ширхэг буюу 67 сая 474 мянга 549 төгрөгний үнэт цаас татан авч, хэлтэс, нэгжүүдэд 251793 ширхэг буюу 81 сая 197 сая 789 төгрөгний үнэт цаас тараан олгосон.

Гэрчилгээ, үнэт цаасны зарцуулалтад сар бүр тогтсон хугацаанд хяналт тавин ажиллаж байна. 2022 оны 2 дугаар улирлын байдлаар 1339 ширхэг үнэт цаас “Өмч хамгаалах зөвлөл”-өөр актлах шийдвэр гаргаж данснаас хассан. Үүнээс 738 ширхэг нь ажилтны алдаа, 601 ширхэг нь техникийн алдаа гарсан байна. Алдаа гаргасан ажилтнуудаар 204323.60 төгрөгийн төлбөрийг бүрэн төлүүлсэн.

2022 онд Нийслэлийн өмчийн харилцааны газраас ирсэн шалгалтаар 90 онооноос 89 оноо авч “Хангалттай” үнэлэгдсэн.

## **1.9 АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШИЙДВЭРЛЭЛТИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД**

### **1.9.1 Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:**

Баримт бичгийн шийдвэрлэлт болон бусад мэдээллийн эрэлт хайлтыг шуурхай болгох үүднээс газарт ирсэн баримт бичгийг “Албан хэрэг хөтлөлтийн E-DOC програм”-д бүртгэн цахим санамжид оруулан ажиллалаа.

- ❖ Тайлангийн хугацаанд **10972** албан бичиг хүлээн авч edoc програмд бүртгэснээс хариутай бичиг **3466** байна. Дээрх албан бичгээс **6902** нь албан хэрэг хөтлөлтийн edoc систем хэрэглэгч байгууллагууд цахим хэлбэрээр ирсэн бол үлдсэн **4067** албан бичгийг байгууллага дээр скайнердаж цахимжуулсан байна. Мөн able програмд нийт 38 албан бичиг бүртгэгдэж шилжүүлэн шийдвэрлэсэн. Албан бичгийн шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд ирсэн бичгийн шийдвэрлэлт **98,3%**, шийдвэрлэлтийн дундаж хоног **12** хоног 24 цаг байна.
- ❖ Энэ онд нийт **46** тушаал /Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр-16, Хүний нөөцийн чиглэлээр-30/ гаргаж edoc-т **6514** албан бичгийн төслийг холбогдох ажилтнуудаас хүлээн авч, удирдлагаар баталгаажуулан хэвлэмэл хуудсанд буулган албажуулан, нэгдсэн дугаар олгож явуулсан. Эдгээрээс Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад архив, албан хэрэг хөтлөлтийн програмаар илгээж бусад албан бичгүүдийг дугтуйлан хаяглаж, шуудангаар холбогдох газарт нь хүргүүлсэн.ABLE програмаар 34 албан бичиг хүлээн авсан байна.




- ❖ Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” захирамжийн дагуу 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс И-ТОКЕН буюу тоон гарын үсгэнд бүрэн шилжсэн бөгөөд газар, хэлтсийн дарга нар тоон гарын үсэг ашиглаж нийт **173** албан бичиг холбогдох газруудад хүргүүлсэн байна.
- ❖ Газрын албан хэрэг хөтлөлтийн талаарх ирсэн, явсан бичгийн тайланг 7 хоног бүрээр, баримт бичгийн шийдвэрлэлтийн мэдээ, баримт бичгийн эргэлтийн мэдээг 14 хоног тутамд гарган ажилласан.

### **Байгууллагын архивын чиглэлээр:**

- ❖ Архивт баримт шилжүүлэх үед хадгаламжийн нэгжид нягтлан шалгалт хийсэн.
- ❖ Хүлээн авсан хадгаламжийн нэгжид хадгалах хугацааны ангиллаар данс бүртгэл үйлдсэн.
- ❖ Архивын цэвэрлэгээ, үйлчилгээ хуваарийн дагуу тогтмол хийгдэж байна.
- ❖ Байгууллагын архивын чийг, дулааныг өдөр тутам тогтмол хэмжиж, тэмдэглэл хөтөлж байна.
- ❖ Албан хаагчдын албан хэрэгцээнд архивын баримт ашиглуулахдаа бүртгэлийг тогтмол хөтөлж байна.
- ❖ Хэвлэмэл хуудасны тайланг хүлээн авч, хүчингүй болсон хэвлэмэл хуудас байхгүй байна.
- ❖ Газрын 2021 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан батлуулж, 2021 онд хөтлөгдсөн баримт бичгийг Архивын тухай хуулийн дагуу байгууллагын архивт 2022 оны 1 дүгээр улиралд бүрэн хүлээн авсан байна.

Байгууллагын архивт байнга хадгалах 33, 70 жил хадгалах 21, түр хадгалах 567 нийт **621** баримт хүлээн авсан байна.



Энэ оны эхний хагас жилийг 2021 оны мөн үетэй харьцуулахад ирсэн, явсан бичиг, хариутай бичиг өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь 2021 онд цар тахлын нөхцөл байдлаас болж хөл хорио тогтоож байгууллагууд хэвийн үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болсонтой холбоотойгоор албан бичгийн тоо бага байж, 2022 онд хөл хорио тавигдаж байгууллага, аж ахуй нэгжүүд хэвийн үйл ажиллагаа явуулдаг болсонтой холбоотой.

### 1.9.2 ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШИЙДВЭРЛЭЛТИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

Тус газарт 2021 оны 12 дугаар сарын 26-наас 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрүүдэд иргэн, хуулийн этгээдээс 167 өргөдөл, гомдол, хүсэлт, санал ирсэн байна.

Үүнд:

- Гомдол – 113
- Хүсэлт – 32
- Санал – 1
- Талархал -21 тус тус ирүүлсэн байна.


#### Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг харьяалалаар харвал

№	Нэгж	Хүсэлт, санал		Өргөдөл, гомдол		Нийт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Баянгол дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс	6	33%	12	67%	18	67%
2	Баянзүрх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс	11	28%	28	72%	39	31%
3	Хан-Уул дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс	4	19%	17	81%	21	15%
4	Сонгинохайрхан дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс	6	27%	16	73%	22	28%
5	Сүхбаатар дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс	17	55%	14	45%	31	9%
6	Чингэлтэй дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс	6	32%	13	68%	19	7%
7	Нийслэл дэх улсын бүртгэлийн газар	4	24%	13	76%	17	7%
Нийт		54	32%	113	68%	167	100%

#### Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг ирүүлсэн сувгаар нь:

№	Ирсэн хэлбэр	Тоо	Хувь
1	1800-1200	31	28%
2	ЗГ 11 – 11	108	47%
3	Бичгээр / ННЗБ/	24	23%
4	И-сервис	4	2%
Нийт		167	100%

#### Өргөдөл, гомдлыг хэлтэс нэгжээр нь харьцуулж харвал



### Нийт гомдлыг агуулгаар харвал

Агуулга	Тоо	Хувь
Байгууллагын үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалттай холбоотой	9	8%
Ажилтны хариуцлага, ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой	34	30%
Эд хөрөнгө эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой	21	19%
Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой	30	26%
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой	6	5%
И – монголиатай холбоотой /гадаад паспорт/	10	9%
Лавлагаа /цахим архив/	3	3%
<b>Нийт</b>	<b>113</b>	<b>100%</b>

### Иргэдээс ирүүлсэн гомдлыг харьяалал, бүтцээр нь харвал

д/д	Агуулга	Дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс							
		Баянгол	Баянзүрх	Хан-уул	Сонгино хайрхан	Сүхбаатар	Чингэлтэй	Нийслэл	Нийт
1	Байгууллагын үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалттай холбоотой	0	5	1	1	0	2	0	9
2	Ажилтны хариуцлага, ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой	7	11	3	2	5	2	4	34
3	Эд хөрөнгө эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой	1	4	8	1	2	1	4	21
4	Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой	2	4	1	10	5	4	4	30
5	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой	2	0	1	0	1	2	0	6
6	И – монголиатай холбоотой /гадаад паспорт/	0	2	3	2	0	2	1	10
7	Лавлагаа /цахим архив/	0	2	0	0	1	0	0	3
8	<b>Нийт</b>	<b>12</b>	<b>28</b>	<b>17</b>	<b>16</b>	<b>14</b>	<b>13</b>	<b>13</b>	<b>113</b>
9	<b>Хувь</b>	<b>11%</b>	<b>25%</b>	<b>16%</b>	<b>14%</b>	<b>12%</b>	<b>11%</b>	<b>11%</b>	<b>100%</b>


### 2022 оны 5 дугаар сарын байдлаар шийдвэрлэлтийн дундаж хугацаа

д/д	Нэгж	Шийдвэрлэлтийн хугацаа	дундаж	Тоо
1	Баянгол дүүрэг дэх УБХ	07 х 08 цаг 13 минут		18
2	Баянзүрх дүүрэг дэх УБХ	11 х 06 цаг 15 минут		39
3	Хан-Уул дүүрэг дэх УБХ	05 х 15 цаг 46 минут		21
4	Сонгинохайрхан дүүрэг дэх УБХ	07 х 10 ц 00минут		22
5	Сүхбаатар дүүрэг дэх УБХ	13 х 13ц 11минут		31

6	Чингэлтэй дүүрэг дэх УБХ	10 x 14 цаг 50 минут	19
6	Нийслэл дэх УБГ	06 x 21 цаг 7 минут	17
<b>Нийт дундаж</b>		<b>08 хоног 11 цаг 25 минут</b>	<b>167</b>

**Нийт ирсэн 167 өргөдөл, гомдлын 95 хувь нь шийдвэрлэгдсэн байх бөгөөд судлагдаж байгаа 8 өргөдөл, гомдол байна.**

**Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 12 цаг 29 минут байна.** Энэ нь нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаанаас бага хугацаанд шийдвэрлэсэн үзүүлэлттэй байна.



Монгол Улсын ерөнхий сайдаас иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирж буй өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах талаар хийсэн мэдээллийг бүх албан хаагчиддаа нэг бүрчлэн танилцуулах үүргийн хүрээнд Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын Тамгын газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн цахим хурал дээр танилцуулсан мэдээллүүдийг 382 албан хаагчдад танилцуулж, танилцуулсан тухай тэмдэглэл хөтлөн гарын үсэг зуруулсан.

Уг танилцсан тухай тэмдэглэлийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын даргад хүргүүлсэн. Уг асуудлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 187 дугаар тогтоол гарч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нийслэлийн засаг даргын тамгын газрын 2022.01.31-ний өдрийн 03/496 тоотой Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад өгсөн үүрэг даалгавар, 2022.03.10-ны өдрийн 03/1035 тоот “Шалгалтын удирдамж, шалгах хуудас” болон 2022 оны 05 дугаар сарын 11-ний Монгол Улсын Засгийн Газрын дугаар 187 тогтоолыг мөрдлөг болгон өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх, нэг мөр эцэслэн шийдвэрлэх, салбарын бодлого, шийдвэрт тусгах боломжтой ажил хэрэгч саналыг судлан тусгахаар ажиллаж байна.

**Сайжруулалтын арга хэмжээ:**

- Газрын даргын шуурхай хуралдаанд өргөдөл, гомдлын тоон мэдээ, шийдвэрлэлт болон зөрчлийн талаар 8 удаа танилцуулсан.
- Өргөдөл, гомдолд нэр дурдагдсан албан хаагчийг Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Төрийн албан хаагчийн ёс зүй, байгууллагын үйлчилгээний стандарт” сэдэвт 2 удаагийн сургалтад нэр бүхий 17 албан хаагч хамруулж ирсэн өргөдөл, гомдол дээр кейс үүсгэж кейсэн дээр ажиллуулсан.

- Газрын даргын шуурхай хуралдаан дээр газрын даргаас 7 удаа үүрэг даалгавар өгч ажилласан.
- Дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааг шалгах шалгалтын удирдамжийн дагуу 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс 03 дугаар сарын 18-ны өдрийг дуустал шалгалт явуулж дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт шийдвэрлэлт, зөрчлийг шалгаж илтгэх хуудсаар улсын бүртгэлийн ерөнхий газар танилцуулсан.
- “ULAANBAATAR ERP” програмд өөрчлөлт оруулах тал дээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт санал хүргүүлсэн.
- Улсын бүртгэлийн ерөнхий газарт өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал хүргүүлсэн.

### **1.10 МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

#### ***Мэдээллийн сан, программ хангамжийн үйл ажиллагаа.***

Газрын тоног төхөөрөмж, сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах, ашиглалтад хяналт тавих, мэдээллийн нэгдсэн сангийн хадгалалт, хамгаалалт, бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй системүүдийн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна.

Тоног төхөөрөмж, програм болон сүлжээний аюулгүй байдлыг тасалдуулахгүй ажиллах хүрээнд тоног төхөөрөмжийн засвар гэмтлийг тухай бүр оношлон шуурхай засварлаж бүртгэл хөтлөн ажиллаж байна.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын-системээр хүнийн нөөцийн удирдлага, утасны жагсаалт, цаг бүртгэл, мэдээ мэдээлэл, ажлын хэсэг, хурал, уулзалт, үүрэг даалгавар, олон нийтийн сүлжээ, тайлан судалгаа, өргөдөл гомдол, үндсэн хөрөнгө бүртгэл, үйл явдал, судалгаа авах, байгууллагын архив, албан хэрэг хөтлөх, дотоод мессенжер гэх мэт маш өргөн боломжтой цогц системийг албан хаагч нарт хандах эрхийг тохируулан ажиллаж байна.

### **1.11 БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ СУРТАЛЧИЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД**

#### **1.11.1 Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал**

Байгууллагын ил тод нээлттэй, шуурхай хариуцлагатай байдлыг хангаж, төр иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх зорилгоор байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчилж мэдээлэх, иргэдийн санал бодлыг сонсох, “Нээлттэй хаалганы өдөр”, бүртгэлийн “Ёслолтой арга хэмжээ”, иргэдэд чиглэсэн бусад үйл ажиллагааг тогтмол зохион байгуулан үйл ажиллагааны төлөвлөгөөндөө ил тод, нээлттэй, хариуцлагатай, хүнд сурталгүй, авлигаас ангид төрийн үйлчилгээг төлөвшүүлэх зорилтуудыг тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

- ❖ Монгол Улсын Засгийн газрын 411 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам батлах тухай”, 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу байгууллагын эрхэм зорилго, тэргүүлэх чиглэл болон байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, заавар, төр засгийн бодлого шийдвэртэй холбогдсон мэдээ,



мэдээллийг “Мэдээллийн самбар”, цахим дэлгэц, байгууллагын болон хэлтэс нэгжийн цахим хуудас, фэйсбүүк хуудсанд бүрэн байршуулж, мэдээллийг тухай бүрт шинэчлэн ойлгомжтой байдлаар байршуулсан.

- ❖ Байгууллагын хэмжээнд иргэдийг цагийн хуваарьгүйгээр хүлээн авч, санал хүсэлтийг шийдвэрлэн ажиллаж байна. Газрын нийт албан хаагчид болон өргөдөл, гомдол хүлээн авах ажилтны мэдээллийг газрын цахим хуудсанд нээлттэй байршуулан, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн төлөвлөлтийн систем /ERP/-д цахим өргөдөл, гомдлын дэд системийг ашиглан, Засгийн газрын 11-11 төв, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүд, Шуурхай удирдлага, зохицуулалтын төв, [www.ub1200.mn](http://www.ub1200.mn) цахим хуудас, smart UB, Clean UB аппликейшн, 1800-1200, бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890 тусгай дугаарын утас, газрын 7777-1890 болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын болон тус газрын веб хуудас, хэлтэс нэгжүүдийн ажлын байр, иргэдээс санал хүсэлт авах хайрцаг, дэвтэр зэрэг эх сурвалжаар иргэд, байгууллагаас **167** хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэн ажилласан.

#### **Байгууллагын албан ёсны цахим хуудас болон нүүр номоор сурталчилсан байдал:**

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ мэдээлэл болон хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг бүхий л арга хэлбэрээр шуурхай хүргэхийн зэрэгцээ бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд:

- ❖ Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, газрын төсөв санхүү, орлого, зарлагын гүйлгээний мэдээ, мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан олон нийтэд мэдээлсэн.
- ❖ Нийслэл болон хэлтсүүдийн цахим хуудас, нүүр хуудсанд /FACEBOOK/ нийт **518** удаа шинэ мэдээ, мэдээлэл оруулж, нийлбэр дүнгээрээ **517103** харилцагч зочилж, улсын бүртгэлийн хууль тогтоомж, үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл шинээр авсан байна.
- ❖ Тайлангийн хугацаанд байгууллагын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах ажлын хүрээнд 6 удаа телевизээр, 7 удаа радио болон бусад мэдээлэлийн сувгаар Улсын бүртгэлийн үйл ажиллагаа, бүртгэлийн үйлчилгээг суртчилан иргэд олон нийтийг 13 удаа мэдээ, мэдээллээр хангаж ажилласан байна.
- ❖ Тус газрын 77771890 тусгай дугаарын утсаар 888, хэлтсүүдийн лавлах утсаар 8475, нийт 9363 иргэн, хуулийн этгээдийг мэдээ, мэдээллээр ханган ажилласан.
- ❖ “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд нийслэлийн бүх хороодоос иргэдэд тоон гарын үсэг олгож эхэлсэн тухай болон иргэдийг тоон гарын үсгээ аваарай гэсэн уриалга бүхий олны танил хүмүүсийг оролцуулсан нийт 10 шторк бэлтгэн байгууллагын албан ёсны цахим сайт, нүүр хуудсанд @Тоон гарын үсэг гэж “хаштаг” байршуулсан байна.
- ❖ Иргэний баримт бичгийг ёслолтой гардуулж, байгууллагын үйл ажиллагааг сурталчилан ажиллах хүрээнд гэрлэлтийн 102 бүртгэл, 105 шинэ төрсөн

хүүхдийн төрсний гэрчилгээ, 16 насанд хүрч шинээр иргэний үнэмлэх авч байгаа ерөнхий боловсролын дунд сургуулийн 163 сурагчдад иргэний үнэмлэхийг ёслолтой гардуулж, нийт **370** бүртгэлийг ёслолтой гардуулж улсын бүртгэлийн үйл ажиллагааг сурталчилсан байна. Эдгээр арга хэмжээнүүдийг тухай бүр сурталчилан ажилласан.



### **1.11.2 Хүний нөөцийн ил тод байдал:**

Энэ хүрээнд <https://www.niislel@burtgel.gov.mn> байгууллагын цахим хуудаст хүний нөөцийн ил тод байдалтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, Байгууллагын бүтэц, орон тоог баталсан тушаал, баталсан орон тоонд ажиллаж байгаа албан хаагчдын мэдээлэл, албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулсан тухай тушаал, хүний нөөцтэй холбоотой мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.

### **1.11.3 Төсөв санхүүгийн ил тод байдал:**

Газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг байршуулан ажиллаж байна.

Тус байгууллагын шилэн дансанд [/https://www.niislel@burtgel.gov.mn/](https://www.niislel@burtgel.gov.mn) нийт 5 удаа 61 мэдээллийг байршуулсан.

### ***Улсын бүртгэлийн байгууллагын “Үйлчилгээний стандарт”-ын хэрэгжилтийг хангах, мэргэжил арга зүйгээр хангах чиг үүргийн хүрээнд:***

Дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүдэд “Байгууллагын үйлчилгээний стандарт”-ын хэрэгжилтийг хангах, өдөр тутам хяналт тавих, тайлагнах зэрэг чиг үүргийг тухайн нэгжийн хэлтсийн дарга, улсын ахлах бүртгэгч нар хэрэгжүүлж, сар бүр НУБГ\_СТ\_1, НУБГ\_СТ\_2 маягтаар хэрэгжилтийг дүгнэж, газарт ирүүлж хэвшсэн.

Дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүдээс ирүүлсэн “ДҮГНЭХ ХУУДАС”-ыг Нийслэлийн хэмжээнд нэгтгэн дүгнэхэд **97** хувийн үзүүлэлттэй байна.

Байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:



- Тус газраас харилцагчийн үйлчилгээний чиглэлээр хэлтсүүдэд 2 удаагийн чиглэл хүргүүлсэн.
- Газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2022 оны 3, 4 дүгээр сард ажлын хэсэг томилогдон 8 дүүрэгт ажиллаж байгаа ажилтан, албан

хаагчдын ажлын байрны нөхцөл байдал, Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт"-ын хэрэгжилт, Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн байдалд шалгалт хийсэн.

- Байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр тус газарт шинээр томилогдсон төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүй ба байгууллагын үйлчилгээний стандарт” сэдвээр 3 удаа зохион байгуулав. Сургалтад 2021 оны 4 улирал, 2022 онд шинээр томилогдсон 21 шинээр томилогдсон төрийн захиргааны, үйлчилгээний болон гэрээт ажилтнуудад улсын бүртгэлийн хууль тогтоомж, дотоод журам, авлигаас урьдчилан сэргийлэх болон авилгын эсрэг хуулийн хэрэгжилт, төрийн албаны болон улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчийн ёс зүй, байгууллагын үйлчилгээний стандарт тус газрын бүтэц, чиг үүргийн тухай мэдлэг, мэдээлэл олгох сэдэвт 2 удаагийн сургалтыг зохион байгууллаа.
- Тус газарт өргөдөл, гомдолд нэр дурьдагдсан албан хаагчдад “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” ба “Байгууллагын үйлчилгээний стандартын тухай мэдлэг, мэдээлэл олгох” сургалтыг 2 удаа зохион байгуулж 2022 оны эхний хагас жилд өргөдөл гомдолд нэр нь дурьдагдсан 17 албан хаагч хамрагдаж, тодорхой кейсүүд дадлага ажил хийлээ.
- Тайлангийн хугацаанд “Азийн сан”, Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран 200 ширхэг баррель үсэгтэй гарын авлагыг дахин хэвлүүлэн 9 дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс, Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвүүд, 171 хороонд хүргүүлсэн.
- Байгууллагын үйлчилгээний стандартад тавигдсан шаардлагын дагуу газрын хэмжээнд үйлчилгээний бүх цэгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд дугаар харгалзахгүй үйлчилгээ үзүүлэх тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан.
- Монголын Үндэсний ТВ-тэй хамтарч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээний төрлийг танилцуулах, бүрдүүлэх баримтын талаарх дохионы хэлний тайлбар бүхий видео танилцуулгыг үйлчилгээний танхимд байршуулав.
- Сүхбаатар дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсээс Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх өрөөг бэлтгэн тохижуулж хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн эхчүүд, өндөр настан иргэдэд бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй үзүүлж ажиллаж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх аяны хүрээнд 7 иргэнийг бичиг баримтжуулж, Өөрийн биеэр ирж бүртгэл хийлгэх боломжгүй 115 иргэнд гэрт нь очиж улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна.
- Үйлчилгээний байрны үүдний хэсгийг тэргэнцэртэй иргэн орох налуу шатыг хийсэн.
- Үйлчилгээний байрны гаднах зогсоолд хөгжлийн бэрхшээлтэй иргэн автомашинаа байршуулах тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан.
- Албан хаагчдыг дохионы хэлний сургалтанд хамруулсан.

**Харилцагчийн үнэлгээний систем нэвтрүүлж, үр дүнг тооцох чиглэлээр:**

Албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ажлын бүтээмж болон гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлэх зорилгоор ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу харилцагчдад үйлчилгээ үзүүлж буй албан хаагч нэг бүрийн цонх бүр дээр “Албан хаагчдын хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ авах” QR кодыг байршуулан харилцагчдаас үнэлгээ болон санал хүсэлт авч ажиллалаа. Тайлангийн хугацаанд 346 харилцагч үнэлгээ өгсөн байна. Үнэлгээ өгсөн байдлыг нэгжүүдээр авч үзвэл хороодод– 65.6%, НҮНТ– 15.9%, дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүдэд-18.5%, дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн “Нэг цонх”-ны үйлчилгээний танхимд болон хороодын нэг цонх, танхимуудад QR код байршуулсан байна.




## ХОЁР.УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА


### 2.1.ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЧИГЛЭЛЭЭР:

Нийслэлийн хэмжээнд 2022 оны 5 дугаар сарын 25-ны байдлаар **283036** иргэнд иргэний бүртгэлийн үйлчилгээг газар, 9 дүүрэг болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв, хороодоор хүргэн ажилласан байна. Үүнд:

- ❖ Иргэний гэр бүлийн бүртгэл-24332
- ❖ Шилжилт хөдөлгөөн-31274
- ❖ Хот доторх шилжилт хөдөлгөөн-27194
- ❖ Иргэний үнэмлэхний бүртгэл-41189
- ❖ Үндэсний энгийн гадаад паспорт олголт-69086
- ❖ Лавлагаа олголт-89961



Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй байна.



Үндэсний энгийн гадаад паспорт олгох үйлчилгээ 2021 оны мөн үетэй харьцуулахад 3,3 дахин ихэссэн үзүүлэлттэй байна. Энэ нь Ковид-19 цар тахлаас үүдэлтэй гадаадад зорчих хөдөлгөөнд хязгаарлалт тавигдсантай холбоотой.

## **2.2 ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЧИГЛЭЛЭЭР:**

Нийслэлийн хэмжээнд 2022 оны 5 дугаар сарын 25-ны байдлаар **110760** эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнд:

- ❖ Анхны бүртгэл-14495
- ❖ Өмчлөх эрх шилжих гэрээ-20120
- ❖ Барьцааны гэрээ-61998
- ❖ Бусад гэрээ-504
- ❖ Бүртгэлд өөрчлөлт оруулах-4102
- ❖ Лавлагаа, хуулбар-7960
- ❖ Тусгай болон урьдчилсан тэмдэглэлийн дүн-278
- ❖ Үрэгдүүлсэн гэрчилгээ дахин олгох-516
- ❖ Хувийн хэрэг хаах-787






Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг 2021 оны мөн үетэй харьцуулахад 0.89 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### 2.3 ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЧИГЛЭЛЭЭР:

Нийслэлийн хэмжээнд 2022 оны 5 дугаар 25-ны байдлаар 10123 хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд:

- ❖ Анхны бүртгэл-1833
- ❖ Дахин авсан-490
- ❖ Нэр олгох-1745
- ❖ Хуулийн этгээдийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах-2653
- ❖ Хуулийн этгээдийн үйлчилгээ явуулах эрхийг сунгах-621
- ❖ Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой бусад бүртгэл-1540
- ❖ Лавлагаа-1241



Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2022 онд иргэдэд үзүүлсэн үйлчилгээ нь 2021 оны бүртгэлээс өссөн үзүүлэлттэй байна.

Дээрх 3 төрлийн улсын бүртгэлийн үйлчилгээний төрлөөр 2022 оны 5 дугаар сарын байдлаар нийслэлийн хэмжээнд нийт 403919 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.



Тус газрын 2022 онд иргэд, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээ нь 2021 оны мөн үеийнхээс өссөн байна.

### 2.4 БИЧИГ БАРИМТЖУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны “Орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 137 дугаар тогтоол Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/487 дугаар захирамжийг үндэслэн Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгмийн олон талт үйлчилгээнд хамруулах зорилгоор иргэдийн бичиг баримтын зөрчлийг арилгах ажлын хүрээнд Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

зөвлөл, “Зөв амьдрах ухаан” төрийн бус байгууллага, ШШГЕГ-ын харъяа Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан хөдөлмөр хийлгэх газар, Улаан загалмайн нийгэмлэг, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, дүүргийн хөдөлмөр халамжийн газар, банк бус санхүүгийн байгууллага зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласан.

**Тайлангийн хугацаанд зорилтот бүлгийн болон бичиг баримтгүй 246 иргэнийг бичиг баримтжуулан ажиллалаа.**



### **2.5. УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Архивын хэлтэс нь төрөөс архивын үйл ажиллагааны талаар явуулж буй бодлого чиглэлийг нийслэлийн бүртгэлийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх, бүртгэлийн үйл ажиллагааны явцад бий болсон баримтыг архивт хүлээн авах, нөхөн бүрдүүлэлт хийх, эмхлэн цэгцлэх, нягтлан шалгах, журмын дагуу хадгалж хамгаалах, ашиглуулах, лавлагаа мэдээлэл, хуулбар олгох, данс, тоо бүртгэл хөтлөх, архивын ажлын хяналт шалгалт хийх, дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүдийн архивын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллах чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн архивын байранд байнга хадгалах үл хөдлөх хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн “Y” дугаарын эх нотлох баримт болох хувийн хэргийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын архив, үйлчилгээний цогцолбор төв рүү хэсэгчлэн нүүлгэн шилжүүлж, архивын өрөөний багтаамжийг нэмэгдүүлж, газраар байрлуулсан хувийн хэргийг тавиурт байрлуулах ажлыг хийж, мөн Багануур дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн архивын данс бүртгэлийг шинээр үйлдүүлж, байгууллагын архивт холбогдох баримтыг улсын бүртгэлийн эх нотлох баримтаас салган шилжүүлж, Хан-Уул дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн төрөлжсөн архивт байсан сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой үүссэн баримтыг газрын байгууллагын архивт авсан. Мөн үл хөдлөх эд хөрөнгийн 1600 ширхэг цаасан хавтас, өдөр тутмын шинээр үүссэн хувийн хэргийн эмх цэгцийг хангаж 2 ширхэг сейфийг удирдлагад танилцуулан шийдвэрлэж, Баянгол дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн архивын өрөөнд 4 ширхэг гэрлийг шинээр тавьж, Сонгинохайрхан дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн архивын нягтруулсан сейфийн засвар, шинэчлэлтийг шийдвэрлэж, хувийн хэргийн хавтсыг бор цаасан хавтсаар солих ажлыг эхлүүлсэн.

2022 оны эхний хагас жилийн байдлаар хувийн хэргийн нүүлгэлттэй холбоотой 1,700,000, сейф нүүлгэлт 5,816,400, сейф засвар 3,128,800, галын хор 3,570,000, архивын хайрцаг 2,400,000 нийт 16,615,200 төгрөгийг зарцуулсан байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар хувийн хэргийн нүүлгэлттэй

холбоотой 1,700,000, сейф нүүлгэлт 5,816,400, сейф засвар 3,128,800, галын хор 3,570,000, архивын хайрцаг 2,400,000 нийт 16,615,200 төгрөгийг зарцуулсан байна.

2022 оны 2 дугаар сарын 18-ны өдөр тус газрын даргаас төвийн 6 дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн дарга нарт хугацаатай үүрэг даалгавар өгч, бэлтгэл ажлыг ханган 02 дугаар сарын 20-ны өдрөөс 3 дугаар сарын эхний долоо хоногт багтаан үл хөдлөх эд хөрөнгийн “Ү” дугаарын эх нотлох баримт болох 01-5000 хүртэлх хувийн хэргийг Улсын бүртгэлийн архив үйлчилгээний цогцолбор байр луу нүүлгэн шилжүүлж, санд байрлуулах ажлыг зохион байгуулахыг үүрэг болгосны дагуу ерөнхий зохион байгуулалтыг хэлтсийн ахлах мэргэжилтэн ахалж, эх нотлох баримтыг дугаарлан хайрцаглаж, бүртгэлжүүлэх ажлыг дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагч, судлаач архивч нар хариуцан хяналт тавьж ажилласан. 2 дугаар улиралд Хан-Уул дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн байранд засвар орсонтой холбогдуулан нягтаршуулсан сэйфэнд багтахгүй байгаа үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн Ү дугаарын 4000 ширхэг хувийн хэргийг нэмж Улсын бүртгэлийн архивын нэгдсэн цогцолбор байранд нүүлгэсэн. Сонгинохайрхан дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн “Ү” дугаарын 5000 ширхэг хувийн хэргийг 85 хайрцагаар багцлан, Баянзүрх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн “Ү” дугаарын 10000 ширхэг хувийн хэргийг 309 хайрцагаар багцлан, Баянгол дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн “Ү” дугаарын 10004 ширхэг хувийн хэргийг 159 хайрцагаар багцлан, Чингэлтэй дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн “Ү” дугаарын 26004 ширхэг хувийн хэргийг, Хан-Уул дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн “Ү” дугаарын 10003 ширхэг хувийн хэргийг 152 хайрцагаар багцлан, Сүхбаатар дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн “Ү” дугаарын 10000 ширхэг хувийн хэргийг 375 хайрцагаар багцлан нийт 71011 ширхэг дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн архивт байршуулсан эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн эх нотлох баримт болох “Ү” дугаарын хувийн хэргийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын архив, үйлчилгээний цогцолбор төв рүү нүүлгэн шилжүүлж, санд өрж байрлуулав.



Архив, албан хэрэг хөтлөлтийн анхан шатны мэргэшүүлэх сургалтад 3 албан хаагчийг суралцах нөхцлөөр хангаж, сургалтын төлбөрт 750.000 төгрөгийг шийдвэрлэж, албан хаагчид амжилттай суралцан төгсч, “Архивч ” мэргэшлийн үнэмлэх авсан.

УБЕГ-ын Улсын бүртгэлийн нэгдсэн архивийн газраас 2022 оны 10/05 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл зөвлөмжийн дагуу нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын даргын 2022 оны А/02 тоот тушаалыг хэрэгжүүлж, хадгалах хугацаа дууссан 686564 хуудас баримтыг устгах ажлыг хууль тогтоомжид заасан хугацаанд

800000 төгрөгийн зардал төсөвлөж Ажлын хэсгийг дүүрэг тус бүрт байгуулан хийж гүйцэтгэсэн.



## **ГУРАВ. НӨХӨН СОНГУУЛИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД:**

### **1.1 Багахангай, Сонгинохайрхан дүүрэгт явагдах нөхөн сонгууль:**

Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 21-ний А/04 тоот “Нөхөн сонгуулийн тов зарлах тухай” тогтоол, Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 24 дүгээр тойрогт нөхөн сонгууль товлон зарласантай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” 2022 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/284 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нөхөн сонгууль явуулах хорооны шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 4 дүгээр сарын 20-ны өдрөөс түр хугацаагаар зогсоосон.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг өглөөний 2022 оны 5 дугаар сарын 23-нд хэвлэж, хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч, иргэний бүртгэлийн улсын ахлах бүртгэгч нар хэвлэлтийн явцад байнгын хяналт тавьж, 2 хувь программаас хэвлэсэн сонгогчийн нэрийн жагсаалтыг нэг бүрчлэн хянаж, тамга тэмдэгээр баталгаажуулж, сонгуулийн хэсгийн хороонд хүлээлцэх актыг үйлдэж, сонгогчдын нэрийн жагсаалтыг сонгуулийн хэсгийн хороо болон итгэмжлэгдсэн ажилтанд 2022 оны 5 дугаар сарын 23-ны өдөр хүлээлгэн өгсөн.

Газрын даргын 2022 оны Б/27 дугаар тушаалаар Багахангай, Сонгинохайрхан дүүрэгт ажиллах 5 итгэмжлэгдсэн ажилтны тушаалыг гаргаж, итгэмжлэгдсэн ажилтанаар ажиллах албан хаагчдаас нууцын баталгаа гаргуулж, гэрээ байгуулах, Итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах ажилтан нарт эрх зүйн сургалтыг танхим болон цахимаар зохион байгуулах, сонгуулийн хууль тогтоомжид заасны дагуу сонгогчийн нэрийн жагсаалтыг хэвлэж, хэсгийн хороонд сонгогчийн нэрийн жагсаалтыг хүргүүлэх ажлыг зохион байгуулах, Сонгогчийн нэрийн жагсаалтад хуульд заасны дагуу өөрчлөлтийг тусгаж, лавлагаа хэвлэх ажлыг зохион байгуулах, /хянах, хэвлэх/, Сонгуулийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, аюулгүй байдлыг хангах цагдаагийн албан хаагч, нэр дэвшигч, нэр дэвшигчийн менежер, шадар туслагчийн сонгогчийн шилжих хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэн ажиллах зэрэг ажлуудыг төлөвлөн ажиллаж байна.

### **ДӨРӨВ. КОВИД ЦАР ТАХЛЫН ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД**

Гамшгаас хамгаалах бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажилласан тухай өдөр тутмын мэдээ тайланг холбогдох газарт хүргүүлэх тухай:



Засгийн газрын 2022 оны 66 дугаар тогтоолоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн цуцалж, халдварын тархалтын “Шар түвшин”-д шилжсэнтэй холбогдуулан Бүх нийтийн бэлэн болон өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажилласан тухай мэдээллийг авахыг зогсоосон.

Бүх нийтийн бэлэн болон өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажилласан тухай мэдээллийг дүүргүүд дэх улсын бүртгэлийн хэлтсээс өдөр бүр авч нэгтгэж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын хариуцлагатай жижүүр, Нийслэлийн онцгой комиссын Шуурхай штабт тогтсон цагт хүргүүлж ажилласан бөгөөд нийт 34 удаа хүргүүлсэн байна.

Мөн үүнээс гадна Ковид-19 цар тахалтай холбоотой нийт 5 төрлийн мэдээ, санал, судалгаа, илтгэх хуудсыг боловсруулж, холбогдох газар, албан тушаалтанд 22 удаа хүргүүлсэн байна.

### **ТАВ. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ**

Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Нийслэлийн Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах, ажиллах журам батлах тухай” А/247 дугаар захирамжаар болзошгүй гамшиг, аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хор уршгийг арилгах үүрэг бүхий “Нийслэлийн Гамшгаас хамгаалах алба”-ыг нэгдүгээр, “Мэргэжлийн анги”-ийг хоёрдугаар, “Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн ажиллах журам”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсан.

Тус захирамжийн 1 дүгээр хавсралтын 12 дугаар заалтад гамшиг ослын үед орон гэргүй болсон иргэдийг бүртгэх, сураггүй алга болсон иргэдийн мэдээллийг гаргаж удирдлагад танилцуулах, мэдээллийн сан үүсгэх ажлыг зохион байгуулах Нийслэлийн гамшгаас хамгаалах Бүртгэл мэдээллийн албаар тус газрыг, 2 дугаар хавсралтын 16 дугаар заалтад гамшиг ослын үед иргэний бүртгэл, судалгаа хийх, мэдээ, мэдээлэл цуглуулах, хуулийн этгээд, иргэнд шаардлагатай лавлагаа, мэдээлэл гаргаж өгөх Мэргэжлийн ангиар дүүргүүд дэх Улсын бүртгэлийн хэлтсийг тус тус томилж баталсан.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Гамшгаас хамгаалах дадлага, сургууль, бэлэн байдлын үзлэг зохион байгуулах тухай” А/59 дүгээр захирамжийн хавсралтаар Нийслэлийн Засаг даргын нэрэмжит бүртгэл мэдээллийн албаны гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийн хуваарийг баталсан.

Энэ хүрээнд Нийслэлийн онцгой комиссын 2022 оны 02 дугаар сарын 8-ны өдрийн 36 дугаар зөвлөмжийн дагуу Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах 17 заалт бүхий бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулан газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллав.

Төлөвлөгөөний дагуу газрын даргын Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах Ажлын хэсэг байгуулах тухай 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн А/9 дүгээр тушаал, 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар Гамшгаас хамгаалах штаб, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, доорх ажлуудыг хийж бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллав. Үүнд:

- Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө;
- Зарлан мэдээллийн дохио дамжуулах бүдүүвч;
- Гамшгаас хамгаалах дайчилгаа зохион байгуулах төлөвлөгөө;
- Газар хөдлөлт, гал түймрийн аюул тохиолдсон үед албаны эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө;
- Аюулт үзэгдэл, ослын үед орон гэргүй болсон иргэдийг бүртгэх нэгдсэн хүснэгт;
- Нийслэлийн Гамшгаас хамгаалах албадтай болзошгүй цагийн байдалд харилцан ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөг тус тус боловсруулж баталсан.


Албаны даргын ажлын зургийг Хот байгуулалт, хөгжлийн газарт хүсэлт гаргаж, хийлгэв.

Газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн А/13 дугаар тушаалаар “Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх” ажлын хэсэг байгуулан Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийж, тайлан боловсруулсан.

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгтэй холбогдуулан Дүүрэг дэх

Сүхбаатар дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс буюу Мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулав.

Нийслэлийн Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн /2022.02.10/, Гамшгийн эрсдэлийн менежментийн чадавхын үнэлгээний аргачлалын сургалт /2022.04.21/, Засгийн 2011 оны 339 дүгээр тогтоолын дагуу бамшгаас хамгаалах бэлэн байдлын дадлага сургуулилалт /2022.03.24/, Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа /2022.05.04/, Гамшгаас хамгаалах Албаны ромилгоот бүрэлдэхүүн, албан хаагчдын сургалт /2022.05.12/ зэрэг нийт 5 сургалт авч албан хаагчдын гамшгаас хамгаалах мэдлэг, чадавхыг сайжруулав.



Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу Гамшгаас хамгаалах эрсдэлийн үнэлгээг гамшгаас хамгаалах албаны гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах ажлын хүрээнд Нийслэлийн онцгой байдлын газартай хамтран ажиллаж, 2022 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр “Гамшиг, аюулт үзэгдэл, эмзэг байдал, чадавхын ялгаа”, “Байгууллагын гамшгийн эрсдэлийн менежментийн чадавхын үнэлгээний аргачлал” сэдвээр /Нийслэлийн онцгой байдлын газрын Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн, дэслэгч Д.Нямдорж/ сургалт авсан.





Сургалтын үр дүнд байгууллагын гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх багийн бүрэлдэхүүнийг сургаж, дадлагажуулсаны дүнд 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Гамшгаас хамгаалах эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж, үнэлгээний үр дүнг боловсруулсан.



Нийслэлийн онцгой байдлын газрын Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дайчилгаа, улсын албад нүүлгэн шилжүүлэлт хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Гансүх гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулахдаа холбогдуулан хүн нэг бүрийн үүргэвчинд байвал зохих зүйлийн жагсаалтыг танилцуулж, албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллалаа. Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн 2011 оны 8 дугаар зөвлөмжийн дагуу гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт оролцох бүрэлдэхүүний нэг бүрийн хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл, бэлэн байдлын үүргэвчийг жигдрүүлэх, хүн нэг бүрийн үүргэвчинд байвал зохих зүйлийн жагсаалтын дагуу бэлтгэл ажлыг хангуулав.




Нийслэлийн онцгой байдлын газрын галын байцаагчаас 2022 оны 5 дугаар сарын 4-ний өдөр хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө авч ажиллав.





Нийслэлийн онцгой байдлын газартай хамтран 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдөр “Гамшгаас хамгаалах бүртгэл мэдээллийн албаны томилгоот бүрэлдэхүүнд гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх мэдлэг олгох” сургалт зохион байгуулж, сургалтад газрын 24, Сүхбаатар дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн 16, нийт 40 албан хаагч хамрагдлаа.

Уг сургалтаар албан хаагчид “Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо, гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ”, “Гамшгаас хамгаалах албаны журам”, “Мэргэжлийн ангийн дүрэм” зэрэгтэй танилцаж, дадлага сургууль хийв. Сургалтын агуулга өргөн хүрээтэй, сонирхолтой байснаас гадна албан хаагчид гамшгийн үед хэрхэн анхан шатны тусламж үзүүлэх болон хэрхэн өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар дадлага хийв.



2022.05.31-ний өдрийн бэлтгэл

2022.06.02-ны өдрийн бэлтгэл





## 2022.06.06-ны өдрийн бэлтгэл



Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт оролцох бүрэлдэхүүний нэг бүрийн хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл, бэлэн байдлын үүргэвчийг жигдрүүлэв.



Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/59 дүгээр захирамжаар баталсан хуваарийн дагуу Бүртгэл мэдээллийн албаны нийт бүрэлдэхүүн, орон тооны бус штабын бэлтгэл бэлэн байдалд Нийслэлийн Засаг даргын нэрэмжит үзлэг, шалгалт 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулагдаж, тус газрын 27 албан хаагч оролцлоо.

Уг үзлэгээр хүн нэг бүрийн үүргэвчинд байвал зохих зүйл, хувцасны жигдрэлт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал, гамшгаас хамгаалах төлөвлөгөө, сургалт, мэдээллийн сангийн бэлтгэл, бэлэн байдал зэрэг 14 үзүүлэлтээр Нийслэлийн онцгой комиссын орлогч даргын 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдөр баталсан удирдамжаар үзлэг зохион байгуулах ажлын хэсэг шалгалт хийлээ. Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын дарга бөгөөд штабын дарга албан хаагчдыг бүрэн жагсаан команд өгч, хүн нэг бүрийн хувцас, үүргэвчинд бэлэн байвал зохих зүйлсийг шалгуулав.

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийн хөтөлбөрийн дагуу Захиргаа удирдлагын хэлтсийн дарга бөгөөд бүртгэл мэдээллийн албаны штабын дарга Б.Байгалмаа Бүртгэл мэдээллийн албаны үйл ажиллагааны танилцуулгыг хийв.

Мөн үзлэг зохион байгуулах ажлын хэсгээс Штабын бүрэлдэхүүний гамшгаас хамгаалах хууль эрх зүйн мэдлэгийг шалгах тест авч, цагийн байдал дээр ажиллах даалгавар өгч бэлтгэл бэлэн байдлыг шалгаж, Сүхбаатар дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс буюу Мэргэжлийн ангийн иргэний бүртгэлийн мэдээллийн сангийн ашиглалт, гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдалтай танилцаж ажиллав.



**ЗУРГАА. САЙН ҮЙЛСИЙН ХҮРЭЭНД:**

Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан 13 дугаар хорооны Улсын бүртгэгч Н.Энхтуул, 16 дугаар хорооны Улсын бүртгэгч Ж.Наранцэцэг нарт 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр өргөө цагаан гэр олгож, батламжийг гардуулан өгч, 2 албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн.



**ДОЛОО. ЗОХИОН БАЙГУУЛСАН БУСАД АЖИЛ**

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жендэрийн үндэсний хорооноос санаачлан хэрэгжүүлж буй "Харилцан хүндэтгэе" сарын аянд нийслэл, дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон нэгдэж ажилласан. Аяны хүрээнд "ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЕ" нэртэйгээр "Хамт олноо хайрлан хүндэтгэе", "Гэр бүлээ харилцан хүндэтгэе", "Бие биенээ харилцан хүндэтгэе", "Ахмадуудаа харилцан хүндэтгэе", "Хүүхдүүдээ харилцан хүндэтгэе", "Бусдын хийсэн ажлыг хүндэлье", уриатайгаар оролцон нөлөөллийн ажлыг амжилттай зохион байгуулан газар, хэлтсийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж ажилласан.



“Таны эрх таны оролцоо авилгад үгүй гэж хэлье” аяны хүрээнд тус газрын цахим хуудас болон хэлтсүүдийн пэйж хуудсуудаар авлигаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг олон нийтэд мэдээлж ажилласан.



Монгол Улсын Ерөнхий сайдын санаачлагаар "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аяны хүрээнд хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх, эрүүл зөв амьдралын хэв маягийг хэвшүүлж, дадал болгох зорилгоор тус аянд газар, хэлтсийн албан хаагчид идэвхтэй хамрагдаж байна.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын дагуу “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд өрнөж буй “Ногоон хот-Иргэний оролцоо” мод тарих аяны арга хэмжээнд улсын бүртгэлийн албан хаагчид оролцон 2022 оны 5 дугаар сарын 24-нд 1540 мод тарьж ажилласан.







Иргэдийн эрүүл аюулгүй, цэвэр орчинд амьдрах эрхийг хамгаалахад аж ахуй нэгж байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2022 оны А/08 дугаар тушаалын дагуу “ХАВРЫН БҮХ НИЙТИЙН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭ”-ний ажлыг 2022 оны 04 сарын 23-ны өдөр зохион байгуулсан. Уг арга хэмжээнд нийслэл, дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүд бүгд хамрагдсан.



#### **НАЙМ. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТАЛААР:**

1. Хууль хяналтын болон төрийн бусад байгууллагатай хуулийн хүрээнд ажлаа идэвхтэй уялдуулан хамтарч ажиллах;
2. Иргэд, хуулийн этгээдэд үзүүлж буй бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах;
3. Хороодоос ялангуяа алслагдсан хороодоос улсын бүртгэлийн үйлчилгээ авахад үйлчилгээний төлбөр хураамжийн асуудал хүндрэл учруулж байна. Иймээс бүх хороодод цахим төлбөрийн машин байршуулах;
4. Анхан шатны нэгжээс үзүүлэх бүртгэлийн тоог нэмэгдүүлэх.

ХЯНАСАН: ЗАХИРГАА УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.БАЙГАЛМАА

ТАЙЛАН БИЧСЭН:МЭРГЭЖИЛТЭН

Б.ЦЭДЭН



